МӨНГӨ НӨӨЦ БАЯЛАГ
АУДИТ ХХК

“Мөнгө Нөөц Баялаг Аудит” ХХК
Аудит, нягтлан бодох бүртгэлийн зөвлөгөө өгөх
итгэмжлэгдсэн байгууллага

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

“Экодевелопмент Монголиа” ББСБ-ын 2020 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон санхүүгийн тайлангийн тухай

2021 он

“Экодевелопмент Монголиа” ББСБ

Байгууллагын талаарх мэдээлэл

Тусгай зөвшөөрөл :	“Экодевелопмент Монголиа” ББСБ нь Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 200 тоот тогтоолоор үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгогдсон.
Хувь нийлүүлэгчид:	“Ассет элаянс” ХХК 71.43% “Ариун партнерс” ХХК 28.57%
Хаяг:	**“Экодевелопмент Монголиа” ББСБ** Стелла төв, 401 тоот, 4 дүгээр хороо, Баянгол дүүрэг, Улаанбаатар хот, Монгол улс
Аудитор:	**“Мөнгө Нөөц Баялаг Аудит” ХХК** Амгалан-Оршихуйн Ордон, 104 тоот Хүрэнбулаг баг, Баян-Өндөр сум, Орхон аймаг, Монгол улс

2020 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн тайлан бэлтгэх болон батлах удирдлагын хариуцлагын талаарх мэдэгдэл

Энэхүү хараат бус аудиторын тайланд дурдсан хараат бус аудиторын дүгнэлттэй хамт уншигдах дараах мэдэгдэл нь "Экодевелопмент Монголиа" Банк Бус Санхүүгийн Байгууллагын (цаашид "ББСБ" гэх) 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн тайлантай холбоотой удирдлагын үүрэг хариуцлага болон аудиторын хариуцлагыг ялгахад чиглэгдсэн болно.

Удирдлага нь ББСБ-ын санхүүгийн тайлангуудыг СТОУС-н дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй бөгөөд эдгээр санхүүгийн тайлангууд нь 2020 оны 12 сарын 31-ээрх санхүүгийн байдал, тайлант жилийн санхүүгийн гүйцэтгэл, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийг СТОУС-д шаардсаны дагуу үнэн бөгөөд шударгаар илэрхийлсэн байх ёстой.

Санхүүгийн тайлан бэлтгэхэд удирдлага нь дараах зүйлсэд хариуцлага хүлээдэг. Үүнд:

- Тохиромжтой нягтлан бодох бүртгэлийн бодлого сонгож тууштай мөрдөх
- Ул үндэстэй, хянамгай шийдэл гаргах болон тооцоолол хийх
- СТОУС-ыг дагаж мөрдсөн эсэхээ дурдаж хэрэв материаллаг ялгаа буюу өөрчлөлт байгаа бол санхүүгийн тайланд тодруулж, тайлбарлах.
- ББСБ ойрын ирээдүйд бизнесээ үргэлжлүүлнэ гэсэн төсөөлөл нь тохиромжгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайланг өөдрөг ажиллагааны төсөөлөлд үндэслэж бэлтгэх.

Удирдлага нь түүнчлэн,

- Дотоод хяналтын үр дүнтэй тууштай систем боловсруулж, хэрэгжүүлж ажиллуулах
- ББСБ-ын санхүүгийн байдлыг үнэн зөвөөр аливаа хугацаанд харуулахуйц нягтлан бодох бүртгэл хөтлөх ажиллагааг зохион байгуулах
- ББСБ-ын нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь санхүүгийн тайланг СТОУС -ын дагуу бэлтгэхүйцээр зохион байгуулагдсан байх
- Хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын хангах арга хэмжээ авч хэрэгжүүлэх
- Заль мэхний асуудал, алдаа болон бусад зөрчлийг илрүүлэх, тэдгээрээс урьдчилан сэргийлэх зэрэг үүрэг хүлээдэг.

Бид эдгээр үүрэг хариуцлагаа ухамсарлан санхүүгийн тайлангаа Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт, Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох заавар журмын дагуу үнэн зөв бэлтгэсэн гэдгээ баталж байна.

"Экодевелопмент Монголиа" ББСБ-ын 2020 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн тайланг гаргахыг зөвшөөрч батлав.

_____

Захирал

Ш.Түмэнбаяр

Огноо: 2021 оны 03 дугаар сарын 15-ны өдөр

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН
“Экодевелопмент Монголиа” ББСБ-ын
Захирал Ш.Түмэнбаяр танаа

Санхүүгийн тайлангийн талаарх тайлан

Бид “Экодевелопмент Монголиа” ББСБ-ын (цаашид “ ББСБ” гэх) 2020 оны 12 дугаар сарын 31-ээр тасалбар болсон жилийн Санхүүгийн байдлын тайлан, Орлогын дэлгэрэнгүй тайлан, Өмчийн өөрчлөлтийн тайлан болон Мөнгөн гүйлгээний тайлангаас бүрдсэн бусад нэмэлт тайлбар тодруулгыг багтаасан санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Санхүүгийн тайлангийн талаарх удирдлагын хүлээх хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу эдгээр санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах хариуцлага хүлээх бөгөөд мөн залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ.

Аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Бидний хүлээх үүрэг хариуцлага бол өөрсдийн гүйцэтгэсэн аудитад тулгуурлан эдгээр санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт илэрхийлэх явдал юм. Бид Аудитын олон улсын стандартын дагуу аудитаа хийж гүйцэтгэсэн болно. Ёс зүйн шаардлагуудыг дагаж мөрдөж, санхүүгийн тайлангууд материаллаг алдаатай эсэх талаар ул үндэслэлтэй баталгаажуулалт олж авахын тулд аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг эдгээр стандартууд биднээс шаарддаг.

Аудитаар санхүүгийн тайлангууд дахь дүнгүүд болон тодруулгуудын талаар аудитын нотолгоо олж авах горимуудыг гүйцэтгэдэг. Сонгосон горимууд нь аудиторын үнэлэмж, түүний дотор залилан эсвэл алдаанаас шалтгаалсан санхүүгийн тайлангууд дахь материаллаг алдаатай тайлагналын эрсдэлийн үнэлгээнээс хамаардаг. Эдгээр эрсдэлийн үнэлгээг хийхдээ аудитор нь байгууллагын дотоод хяналтын үр өгөөжийн талаар дүгнэлт гаргах зорилго тавилгүйгээр, тухайн нөхцөл байдалд тохиромжтой аудитын горимуудыг зохиомжлохын тулд санхүүгийн тайлангуудыг тухайн байгууллага бэлтгэж үнэн зөв толилуулахтай хамаатай дотоод хяналтыг авч үздэг. Түүнчлэн аудитаар тухайн хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн зохистой байдал болон тооцооллын ул үндэслэлийг үнэлж, мөн санхүүгийн тайлангуудын нийт толилуулгыг үнэлдэг.

Бидний олж авсан нотолгоо нь дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой гэж үзэж байна.

Аудиторын дүгнэлт

Бидний үзэж байгаагаар эдгээр санхүүгийн тайлангууд нь бүхий л материаллаг асуудлаар **“ЭКОДЕВЕЛОПМЕНТ МОНГОЛИА” ББСБ-ЫН 2020 ОНЫ 12 САРЫН 31-**ээрх санхүүгийн байдал, өмчийн өөрчлөлт, тухайн жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу үнэн толилуулж байна.

ОРХОН АЙМАГ
МӨНГӨ НӨӨЦ БАЯЛАГ АУДИТ ХХК

АУДИТОР М.БЯМБАДОРЖ
“Мөнгө Нөөц Баялаг Аудит” ХХК

2021 оны 03 дугаар сарын 15-ны өдөр

АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН
ЭКОДЕВЕЛОПМЕНТ МОНГОЛИА
БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА
2020 оны 12-р сарын 31

(төгрөгөөр)

Үзүүлэлт	2019.12.31	2020.12.31
ХӨРӨНГӨ		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	1,153,500,688.81	1,121,377,304.46
Харилцагчдад олгосон зээл-цэвэр	286,371,058.32	328,217,790.97
Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	1,044,661.65	4,190,417.65
Бусад авлага	619,313.04	0.00
БҮТЭЗ	77,900.00	77,900.00
Үндсэн хөрөнгө-цэвэр	10,502,415.66	5,770,912.66
НИЙТ ХӨРӨНГӨ	**1,452,116,037.48**	**1,459,634,325.08**
ӨР ТӨЛБӨР БА ӨМЧ		
Өр төлбөр		
Богино хугацаат бусад өглөг	475,861.67	475,861.67
ЭМД,НДШ-ийн өглөг	-	0.19
Татварын өр	-	2,459,008.74
Өр төлбөрийн дүн	**475,861.67**	**2,934,870.60**
Өмч		
Энгийн хувьцаа	1,400,000,000.00	1,400,000,000.00
Хуримлагдсан ашиг	51,640,175.81	56,699,454.48
Өмчийн дүн	1,451,640,175.81	1,456,699,454.48
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨМЧ	**1,452,116,037.48**	**1,459,634,325.08**

Захирал **Ш.ТҮМЭНБАЯР**

Нягтлан бодогч **Б.ИЧИНХОРЛОО**

ОРХОН АЙМАГ
МӨНГӨ НӨӨН БАЯЛАГААНЫ ГАЗАР

М.БЯМБАДОРЖ
Аудитор, МНБ
03/15/2021

Жич: Санхүүгийн тайлангийн тодруулгын хамт хэрэглэгдэнэ.

АУДИТЛАГДСАН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН
ЭКОДЕВЕЛОПМЕНТ МОНГОЛИА
БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА
2020 оны 12-р сарын 31

(төгрөгөөр)

Үзүүлэлт	2019.12.31	2020.12.31
Хүү, түүнтэй адилтгах орлого	11,858,591.38	74,614,375.97
Хүү, түүнтэй адилтгах зардал	-	-
Хүүгийн цэвэр орлого	**11,858,591.38**	**74,614,375.97**
Арилжааны орлого	65,288,765.95	
Санхүүгийн үйлчилгээний шимтгэлийн орлого		-
Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн орлого	5,252,472.01	973,625.74
Хүүгийн бус цэвэр орлого	**70,541,237.96**	**973,625.74**
Арилжаа болон ханшийн тэгшитгэлийн зардал	1,168,306.73	129,200.00
Боловсон хүчинтэй холбоотой зардал	51,038,570.47	47,150,236.82
Бусад зардал	25,350,289.01	22,537,725.62
Зээлийн эрсдэлийн зардал	13,625,506.00	-
Хүүгийн бус цэвэр зардал	**91,182,669.21**	**69,817,162.44**
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	15,301,380.39	-
Үндсэн бус үйл ажиллагааны зардал	4,550,000.00	-
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	**1.968,537.52**	**5,770,839.27**
Орлогын албан татвар	186,623.30	-
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	**1,781,914.22**	**5,770,839.27**

Захирал **Ш.ТҮМЭНБАЯР**

Нягтлан бодогч **Б.ИЧИНХОРЛОО**

ОРХОН АЙМАГ
МӨНГӨ НЭГ
БАЯЛАГ АУДИТ
ХХК
6118271333 4408292

М.БЯМБАДОРЖ
Аудитор, МНБ

03/15/2021

Жич: Санхүүгийн тайлангийн тодруулгын хамт хэрэглэгдэнэ.

АУДИТЛАГДСАН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН
ЭКОДЕВЕЛОПМЕНТ МОНГОЛИА
БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА
2020 оны 12-р сарын 31

(төгрөгөөр)

	ҮЗҮҮЛЭЛТ	Хувьцаат капитал	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	**2018 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл**	**1,000,000,000.00**	**49,858,261.59**	**1,049,858,261.59**
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга		-	-
3	**Залруулсан үлдэгдэл**	**1,000,000,000.00**	**49,858,261.59**	**1,049,858,261.59**
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)		1,781,914.22	**1,679,610.34**
5	Өмчид гарсан өөрчлөлт	400,000,000.00		**400,000,000.00**
6	**2019 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл**	**1,400,000,000.00**	**51,640,175.81**	**1,451,640,175.81**
7	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга		-711,560.60	**-711,560.60**
8	**Залруулсан үлдэгдэл**	**1,400,000,000.00**	**50,928,615.21**	**1,450,928,615.21**
9	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)		5,770,839.27	**5,770,839.27**
10	Өмчид гарсан өөрчлөлт			
11	**2020 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл**	**1,400,000,000.00**	**56,699,454.48**	**1,456,699,454.48**

Захирал **Ш.ТҮМЭНБАЯР**

Нягтлан бодогч **Б.ИЧИНХОРЛОО**

ОРХОН АЙМАГ МОНГОЛ БАЛАНС АУДИТ ХХК 6118271333 4408292

М.БЯМБАДОРЖ
Аудитор, МНБ
03/15/2021

Жич: Санхүүгийн тайлангийн тодруулгын хамт хэрэглэгдэнэ.

АУДИТЛАГДСАН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН
ЭКОДЕВЕЛОПМЕНТ МОНГОЛИА
БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА
2020 оны 12-р сарын 31

(төгрөгөөр)

	2019.12.31	2020.12.31
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Мөнгөн орлогын дүн	**97,701,209.73**	**77,760,016.22**
Зээлийн хүүгийн орлого	10,499,450.24	77,517,000.00
Харилцах дансны хүүгийн орлого	1,359,141.14	243,016.22
Банкин дахь хадгаламжийн хүүгийн орлого	-	-
Гадаад валютын арилжааны орлого	65,288,765.95	-
Гадаад валютын ханшийн зөрүүгийн орлого	5,252,472.01	-
Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	171,623.70	-
Бусад үйлчилгээ	15,129,756.69	-
Мөнгөн зарлагын дүн	**70,369,572.15**	**109,883,400.57**
Ажиллагсдад олгосон цалин, нөхөн олговор, тэтгэмж	42,218,370.00	40,852,107.73
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	5,154,653.47	4,550,655.26
Албан томилолт, сургалт	3,665,547.00	-
Ашиглалтын зардалд төлсөн мөнгө	-	-
Шатахуун, шуудан холбоо, интернэт, сэлбэг хэрэгсэл	3,096,023.04	3,767,710.00
Бичиг хэрэг, ариун цэвэр	94,000.00	1,092,680.00
Татвар, даатгалын байгууллагад төлсөн мөнгө	-	-
Зар сурталчилгаа	-	-
Аудит, мэргэжлийн үйлчилгээ	4,408,000.00	-
Зохицуулалтын үйлчилгээний хураамж	2,200,000.00	1,980,000.00
Бусад үйлчилгээ	9,532,978.64	57,640,247.58
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	**27,331,637.58**	**(32,123,384.35)**
ҮНДСЭН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Мөнгөн орлогын дүн	**258,469,686.09**	-
Бусад	258,469,686.09	-
Мөнгөн зарлагын дүн	-	-
Торгууль	-	-
Үндсэн бус үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	**258,469,686.09**	-
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	**285,801,323.67**	**(32,277,976.62)**
МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	**867,699,365.14**	**1,153,500,688.81**
МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	**1,153,500,688.81**	**1,121,377,304.46**

Захирал **Ш.ТҮМЭНБАЯР**

Нягтлан бодогч **Б.ИЧИНХОРЛОО**

ОРХОН АЙМАГ

М.БЯМБАДОРЖ
Аудитор, МНБ

03/15/2021

Жич: Санхүүгийн тайлангийн тодруулгын хамт хэрэглэгдэнэ.